



**БОЛОВСРОЛ,
СОЁЛ,
ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМ**



Дээд Боловсролын Шинэчлэлийн Төсөл

АХБ-ны Төслийн дугаар: 43007-023

Төслийн код: HERP MON Зээлийн дугаар: 2766

Дээд Боловсролын Шинэчлэлийн Олон Улсын Зөвлөх Үйлчилгээ

**Сургалтын хөтөлбөр, сургах, сурах үйл ажиллагааны
зөвлөхүүдийн боловсруулсан бүтээгдэхүүн**

**ДБСБ-УУДЫН ХӨТӨЛБӨРИЙН ЧАНАРЫН БАТАЛГААЖУУЛАЛТЫГ
БҮРЭЛДҮҮЛЭХ УДИРДАМЖ**

Сургалтын хөтөлбөр, сургах, сурах үйл ажиллагааны баг

Dr. Jean-Guy Vienneau

Олон улсын зөвлөх

Dr. А.Амарзаяа

Үндэсний зөвлөх



Улаанбаатар хот

2017 он



PT.TRANS INTRA ASIA

**HERP- CURRICULUM TEACHING AND LEARNING
QUALITY ASSURANCE (QA) FOR CURRICULUM: A CHECKLIST
ХӨТӨЛБӨРИЙН ЧАНАРЫН БАТАЛГААЖУУЛАЛТ(ЧБ): ШАЛГАХ ХУУДАС
BY
AMARZAYA AMARTURSHIN AND JEAN-GUY VIENNEAU
CONSULTANTS**

УДИРТГАЛ

Үндэсний хэмжээнд үзүүлж буй дээд боловсролын үйлчилгээний чанарын хяналтыг тогтооход төдийгүй олон улсын хэмжээнд дээд боловсролын үйлчилгээ үзүүлэхийн тулд чанарын баталгаажуулалт(ЧБ)-ын систем бүрдүүлэх нь зайлшгүй шаардлагатай юм. Чанарын баталгаажуулалтын талаарх ойлголт нь дээд боловсролын байгууллагуудын хувьд оюутнуудын сурлагыг амжилтанд хүргэж, түүнийг тогтвортой хадгалах нөхцлийг бүрдүүлдэх гол хүчин зүйл юм. Монгол улсын их дээд сургуулиуд нь өөрсдийн хэрэгжүүлж буй хөтөлбөрийн чанар болон оюутнуудын амжилтын талаар анхаарч буй. ЧБ нь дээд боловсролд өндөр чанар болон стандартыг бий болгоход чухал үүрэгтэй. Хөтөлбөр, програм нь дээд боловсролын байгууллага(ДББ)-ын амжилтыг илтгэх нэг гол бөгөөд үндсэн үзүүлэлт юм.

Сургуулийн чанарын баталгаажилтыг хангах дотоод ба гадаад гэсэн хоёр хэлбэр байдаг. Гадаад ЧБ нь магадлан итгэмжлүүлэх ажлын хэсэг бөгөөд үүнийг олон улсын байгууллагууд гүйцэтгэдэг бол дотоод ЧБ нь тухайн байгууллагын дотоод асуудал юм. Дээд боловсролын шинэчлэлийн төсөл(ДБШТ)-ийн ажлын даалгаврын хүрээнд ДББ-д өгөх зөвлөгөө, зөвлөмжийг бид энэхүү материалд тусгахаар зорилоо.

Хөтөлбөр, төлөвлөгөөний амжилтыг хэмжих ажил нь эдгээрийн бүтэц, механизм, үзүүлж буй үйлчилгээний үр ашигтай байдлыг шалгах зэргийг дотроо агуулна. Бүхэлдээ хөтөлбөрийн ЧБ нь боловсролын байгууллагын найдвартай байдал, хөрөнгө оруулалтын үр ашиг (бүтээгдхүүн-гарц) зэргийг удирдан чиглүүлж, зохих мэдээллийг оролцогч талууд болон санхүүгийн түншүүдэд бэлдэж өгдөг. Энэ нь мөн тухайн байгууллагын тасралтгүй хөгжих үйл ажиллагаа, санал санаачлагуудыг дотроо багтаадаг.

Дараа дараагийн хуудсуудад оюутан, суралцагчдад толилуулж буй хөтөлбөр, агуулга-контентийн чанарын баталгааг хангахын тулд их дээд сургуулиудад баримтлах гол зарчим, удирдамжуудыг тусгалаа. Эдгээр зарчмууд нь тухайн байгууллага өөрсдийн боловсруулан хэрэгжүүлж буй хөтөлбөрөөр дамжин хүрч буй боловсролын амжилтыг үнэлэхэд ашиглагдах боломжтой.

Чанарын баталгаажилтын зарчим болон зөвлөмж

Дээд зэргийн чанарыг бий болгохын тулд ДББ-ын баримтлах **дөрвөн** зарчим:

- Өөрсдийн үзүүлж буй үйлчилгээг чанартай байлгаж, баталгаажуулах нь дээд боловсролын байгууллагын анхдагч үүрэг юм;
- Чанарын баталгаажуулалт нь дээд боловсролын систем, байгууллага, хөтөлбөр, оюутны ялгаатай байдлыг тооцож үздэг байх;
- Чанарын талаарх соёлын хөгжил, төлөвшилд чанарын баталгаажуулалт нь дэмжлэг үзүүлдэг байх;
- Чанарын баталгаажуулалтад оюутан, бүх оролцогч тал, нийгмийн хэрэгцээ, хүлээлтийг тооцож үзэх шаардлагатай.

Аливаа байгууллагын чанарын баталгаажуулалтын зөвлөмж, удирдамжуудыг бодлого болон процессоор хянаж, чиглүүлж байдаг. Тэдгээр нь байгууллагын тасралтгүй хөгжлийн циклийг бий болгож, байгууллагын найдвартай(accountable) байдлыг бий болгодог

чанарын баталгаажилтын системийн гол тулгуур болдог. Энэ нь дотоодын бүх оролцогч талуудыг чанарын тал дээр хариуцлага хүлээж байгууллагын бүх түвшинд чанарыг баталгаажуулах үйл явцад оролцох чанарын соёлын хөгжлийг дэмждэг. Үүнийг хэрэгжүүлэхийн тулд бодлогыг албан ёсоор батлаж нийтэд хүртээмжтэй болгодог.

Чанарын баталгаажилтын бодлого нь судалгаа, суралцах болон багшлах үйл ажиллагааны хоорондын холбоо, хамаарлыг тооцон, байгууллагын үйл ажиллагаа явуулж буй үндэсний хэмжээний нөхцөл байдал болон байгууллагын дотоод нөхцөл байдал болон стратегийг тооцож үзсэн тохиолдолд илүү их үр нөлөөтэй байдаг. Ийм бодлого нь дараах зүйлийг дэмждэг

- Чанарын баталгаажилтын системийн бүтэц, зохион байгуулалт;
- Тэнхим, сургууль, багш, байгууллагын бусад нэгжүүд болон байгууллагын удирдлага, тухайн багш, оюутнууд чанарын баталгаажилтанд хүлээх хариуцлага;
- Академик нэгдмэл байдал болон академик эрх чөлөө, академик байдлын хулгайнаас сэргийлэх сэрэмж;
- Багш, оюутныг ялгаварлан гадуурхах хэлбэрийн ямарч үйл ажиллагаанаас хамгаалах;
- Гадаад оролцогч талуудыг чанарын баталгаажилтын үйл явцад оролцуулах.

Бодлогыг байгууллагын хувьд өргөн оролцоог хангасан, дотоодын төрөл бүрийн чанарын баталгаажилтын үйл явцуудаар дамжуулан бодит байдал дээр хэрэгжүүлнэ. Бодлогыг хэрхэн хэрэгжүүлж, хянаж, боловсронгуй болгох нь байгууллагын зүгээс тодорхой шийдэл шаарддаг.

Хөтөлбөрийн дизайнчлал ба баталгаажилт

ДББ-ууд хөтөлбөрүүдээ дизайнчилж, батлах өөрийн гэсэн процесстэй байдаг. Хөтөлбөр нь үр дүнд суурилсан байх ёстой ба өөрийн тавьсан зорилгоо биелүүлэхүйцээр дизайнчлагдсан байх шаардлагатай. Хөтөлбөр хэрэгжилтийн үр дүнд гарах зэрэглэлийг тодорхой зааж өгч ойлгомжтойгоор танилцуулах шаардлагатай ба үндэсний хэмжээний дээд боловсролын зэрэг олгох журам, дүрэмтэй нийцсэн байх ёстой.

Хөтөлбөр нь дээд боловсролын байгууллагын багшлах үйл ажиллагааны зорилгын үндэс суурь болж өгөх ёстой. Энэ нь оюутанд академик мэдлэг болон хувь хүний хөгжил мөн ирээдүйн ажил, мэргэжилд нь нөлөөлөхүйц, хувирч өөрчлөгдөх үр чадвар, цогц чадамжуудыг олгодог.

Хөтөлбөртэй холбоотойгоор байгууллагын зүгээс тооцож үзэх шаардлагуудын жагсаалтыг дор өгөв:

- Хөтөлбөрийн нийт зорилго нь байгууллагын стратегитэй уялдсан, суралцахуйн зорьж буй үр дүнг тодорхой томъёолсон байхаар дизайнчлагдсан;
- Оюутан болон бусад оролцогч талуудын оролцоог хангасан байхаар дизайнчлагдсан;
- Хөндлөнгийн эксперт болон тогтоосон түвшний үзүүлэлт(reference points/бенчмарк)-уудыг ашигладаг;
- Оюутны ахиц дэвшлийг хангасан байхаар дизайнчилсан;
- Оюутны ачааллыг тодорхойлох;
- Зохистой газар сайн бүтэцчилэгдсэн байр эзлүүлэх боломжуудтай;
- Байгууллагын албан ёсны баталгаажуулалт авсан.

Оюутан төвтэй сургалт, багшлахуй болон үнэлгээ

Хөтөлбөр нь оюутнуудыг сургалтын процессийг бий болгоход идэвхтэй оролцох оролцоог дэмжиж урамшуулдаг байхаар хэрэгжих явдлыг байгууллага хариуцах ба оюутны үнэлгээ нь энэ арга зүйг тусгах ёстой.

Суралцагч төвтэй суралцахуй ба багшлах үйл ажиллагаа нь оюутны идэвхжил, өөртөө дүгнэлт хийх, сургалтын процессд оролцох оролцоог дэмжихэд чухал үүрэг гүйцэтгэдэг. Энэ нь сургалтын хөтөлбөр мөн үр дүнгийн үнэлгээний дизайнчлал болон хэрэгжилтийг маш хянуур авч үзнэ гэсэн үг юм.

Оюутан төвтэй суралцах болон багшлах үйл ажиллагаа:

- Оюутнуудын янз бүрийн хэв шинж болон тэдгээрийн хэрэгцээг суралцах уян хатан арга замуудыг бий болгох;
- Тохиромжтой үед сургалт явуулах төрөл хэлбэрийн арга замуудыг авч үздэг;
- Заах арга зүйн төрөл бүрийн аргуудыг ашигладаг;
- Хичээл заах хэлбэр болон заах аргуудыг байнга үнэлж, тохиргоог хийдэг;
- Суралцагчийн бие даасан байдлыг дэмжихийн хамтаар багшийн зүгээс өгөх зохистой заавар, дэмжлэгийг өгдөг байх;
- Багш-оюутны харилцааны харилцан хүндлэлийг дэмжиж урамшуулах;
- Оюутны зүгээс гарах санал, хүсэлтийг шийдэх зохистой журам, процедуртай.

МУИС болон зарим сургуулиуд магистр, доктор оюутнууддаа бусад сургуулиудаас хичээл сонгох боломжийг дэмжиж хөтөлбөртөө тусгасан байдаг нь энэ хэсэгт чухал ач холбогдолтой юм. Бусад сургуулиуд ч гэсэн энэ хэлбэрийн сургалтыг ашиглаж, дэмжих нь ДББ-ын чанарын баталгаажилтыг хангахад чухал нөлөөтэй юм.

Оюутны ахиц дэвшил, цаашдын карьерт үнэлгээний үзүүлэх ач холбогдлыг тооцохын тулд үнэлгээний чанарын баталгаажуулалт нь дараах зүйлсийг тооцож үздэг:

- Үнэлгээ хийгчид нь түгээмэл ашиглагдаж буй шалгалтын арга зүйнүүдтэй танил бөгөөд энэ чиглэлээр өөрсдийн үр чадварыг хөгжүүлэх дэмжлэг авдаг;
- Үнэлгээний шалгуур болон арга зүй мөн оноожуулах арга зүйг урьдчилан нийтэд хүргэх;
- Үнэлгээ нь зорьж буй сургалтын үр дүнд оюутнууд ямар хэмжээнд хүрснийг харуулна. Оюутнуудад шаардлагатай тохиолдолд эргэх дүгнэлт өгөх ба энэ нь сургалтын процессд өгөх зөвлөмж, зөвлөгөөтэй холбогдоно;
- Боломжтой бол үнэлгээг нэгээс олон шалгагч хийнэ;
- Үнэлгээний зохицуулалт, журмууд нь онцгүй тохиолдлуудыг тооцож үзэх;
- Үнэлгээ нь нийцтэй байж, бүх оюутнуудад тэгш хандаж, заасан журамын дагуу явагдах ёстой;
- Оюутнуудад зориулсан албан ёсны журам, дүрмүүд хүчин төгөлдөр байх ёстой.
- Ажлын байрны дадлага хийх, сургалт зэрэг сургууль дээр хийдэггүй гэхдээ оюутанд хичээл, судалгаатай холбоотой туршлага олгох үйл ажиллагаанд оюутнуудыг хамруулах.

Хөтөлбөрийн байнгын мониторинг ба үе шаттай хяналт-дүгнэлт

Хөтөлбөрүүд зорилгодоо хүрэх боломж бүрдүүлэх, оюутнууд болон нийгмийн эрэлтийг гүйцэлдүүлэх зорилгоор сургуулиуд өөрсдийн хөтөлбөрөө үе шаттайгаар хянаж үнэлэж байх шаардлагатай. Ийм төрлийн хяналтын ажил нь хөтөлбөрийг байнгын сайжруулалт, шинэчлэл рүү хөтлөнө. Хяналтын үр болгон хийсэн аливаа үйл ажиллагааг оролцогч бүх талуудад мэдээлэх ёстой.

Сургалтын хөтөлбөрийн байнгын хяналт, үнэлгээ, сайжруулалт нь оюутны суралцах орчинг сайжруулах, дэмжих, хөтөлбөрийн хэрэгжилтийг дэмжих зорилготой.

Энэхүү ажил нь дараах зүйлийн үнэлгээг дотроо багтаана:

- Хөтөлбөрийн агуулга нь тухайн судлагдахууны сүүлийн үеийн судалгааны үр дүнгүүдийг тусгаж буй эсэх ингэснээр хөтөлбөр нь шинэлэг, цаг үетэйгээ нийцэж байх;
- Нийгмийн хувирал болон өөрчлөлтийн хэрэгцээ;
- Оюутны ачаалал, ахиц дэвшил, төгсөх төлөвлөгөө;
- Оюутны үнэлгээний үйл явцын үр ашигтай байдал;
- Хөтөлбөр, хэрэгжүүлэх явцад хэрэглэсэн сургалтын стратеги, арга зүйн талаарх оюутнуудын хүлээлт, хэрэгцээ, сэтгэл ханамж;
- Суралцах орчин, дэмжих үйлчилгээ болон тэдгээр нь сургалтын хөтөлбөрийн зорилготой нийцэж буй эсэх.

Хөтөлбөрийг оюутнууд болон бусад оролцогч талуудыг оролцуулан тогтмол үнэлэн, сайжруулдаг. Үнэлгээгээр цуглуулсан мэдээлэлд дүгнэлт өгч хөтөлбөрийг шинэлэг байлгахын тулд засвар, сайжруулалтыг хийнэ.

Хөтөлбөр-каррикулум нь дараах шаардлага, шинж чанарыг хангасан байна:

- Энэ нь сургалтын бүрэн бүхэл үйл ажиллагааны дизайн бөгөөд хөтөлбөрийн зорилгод хүрэхийн тулд хийгдэх бүх үйл ажиллагааны төлөвлөлт, хэрэгжилт, хяналт, үнэлгээний лавлах болж өгнө.
- Хөтөлбөрт хүрээнд тодорхойлсон судлагдхуун болон оролцогч талуудын хэрэгцээг сургууль болон хөтөлбөрийн чанартай стандарт, алсын хараа, зорилгын хүрээнд гүнзгийрүүлсэн судалсан судалгаа.
- Каррикулумыг сургалтын төлөвлөгөөгөөр дамжуулан ШУ, технологийн хөгжил, оролцогч талуудаас шаардаж буй чадвар, чадамж зэргийг тооцон үр шаттайгаар сайжруулдаг.
- Хөтөлбөр нь суралцагч сургалтын төлөвлөгөөний тодорхой үе шатанд эзэмшсэн байх үр чадварын талаар баримтлах гол лавлагаа мөн.
- Хөтөлбөрийг түүний зорилго, материалын цар хүрээ болон гүнзгийрэл, төрөл бүрийн нөхцөл байдалд ашиглагдах хард болон софт үр чадваруудыг эзэмших явдлыг дэмжиж буй зохион байгуулалт зэрэгтэй жишиж үнэлдэг.

Хөтөлбөр нь дараах зүйлийг дотроо агуулна:

- Суурь болон дэмжих үр чадвар, чадамжууд болон зорилго, алсын хараа, үйл ажиллагаандаа хүрэхэд зориулсан бусад зүйлсийн бүтэцчилэгдсэн стандарт.
- Төгсөгчийн үр чадвар эзэмших явдлыг дэмжсэн, суралцагчдад мэдлэгээ өргөсгөх, өөрсдийн сонирхлын дагуу гүн мэдлэг эзэмшихэд зориулсан уян хатан байдлыг бий болгосон курс хичээлүүд болон түүнийг тодорхойлсон хичээлийн тодорхойлолт, силлабус, хичээлийн тодорхойлолт.
- Зорилго, материалын цар хүрээ болон гүнзгийрэл, төрөл бүрийн нөхцөл байдалд ашиглагдах хард болон софт үр чадваруудыг эзэмших явдлыг дэмжиж буй зохион байгуулалт зэрэгтэй жишиж үнэлэгддэг.
- Хичээлийн төлөвлөгөөгөөр дамжин тодорхой хугацаанд багтан холбогдох талууд(нийгэм болон мэдлэгийн)-ын оролцоотой үнэлэлт хийгддэг ба үүний дүнд ШУ, технологийн хөгжил болон оролцогч талуудын хэрэгцээ, шаардлагыг тусгадаг.

Дотоод чанарын баталгаажуулалтын шалгах хуудас

Олон сургууль өөрсдийн хөтөлбөр болон сургалтын системээ дунджаар гурван жил болгон үнэлж байдаг. Дараах **шалгах хуудсыг** сургуулиуд өөрсдийн байгууллага дээр чанарын талаар соёл бүрэлдсэн эсэхийг үнэлэх, бүрдүүлэх зорилгоор ашигладаг:

- Хөтөлбөрийн боловсруулалт нь чанарын циклтэй холбогдсон;
- Бүх шинэ хөтөлбөрүүд нь байгууллагын дотоод болон шинэ хөтөлбөрийн санхүүжилт, бүртгэл, магадлан итгэмжлэлтэй холбоотой гадаад зохицуулалтын хүрээнд боловсруулагддаг;
- Хөтөлбөрийн дизайн болон боловсруулалт нь олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн чанарын ерөнхий шаардлагуудтай нийцтэй;
- Хөтөлбөрийг харгалзах оролцогч талууд(одоогийн болон төгссөн оюутнууд, бусад эрдэмтэд, мэргэжлийн байгууллага, улсын болон хувийн секторт ажиллагчид)-тай зөвлөлдсөний үндсэн дээр боловсруулдаг;
- Хичээл бүрийн хувьд үр дүн болон үнэлгээний шалгуурыг тодорхой зааж бүхэл хөтөлбөрийн үр дүн болохын хувьд нэгтгэгдсэн байх энэ нь боловсруулалт болон үнэлгээний суурь болдог;
- Хөтөлбөр нь харгалзах мэдлэг, үнэт зүйл, шаардлагатай үр чадварыг агуулсан суралцахуйн үр дүнгүүдтэй;
- Үр дүн нь харгалзах үнэлгээний шалгууруудтай холбогдсон ба суралцах үйл ажиллагааны төгсгөл дэхь үр чадварын үнэлгээг тодорхойлдог;
- Багшлах болон сурах үйл ажиллагаа, үнэлгээний арга зүй нь суралцахуйн тодорхой үр дүнгүүдийг дэмждэг;
- Зэрэглэл, хөтөлбөр, хичээл, курс/модулиуд нь сургуулийн чанарын мэдээллийн удирдлагын системд байдаг;
- Үр дүнг чадвар, чадамжуудаар илэрхийлсэн;
- Үр дүнгүүд нь тохиромжтой хэсэг дээрээ слабар хоорондын р дүнгүүдийг агуулсан;
- Үр дүнгүүд үнэлгээний шалгууруудтай холбоотой;
- Үнэлгээний үйл явцыг баталгаажуулахын тулд үнэлгээ ба суралцахуйн үр дүнг хооронд нь тохируулдаг.
- Үнэлгээний шалгуур нь суралцагч цогц чадамжийг хэрхэн эзэмшсэнийг тодорхой харуулна.
- Үнэлгээний төлөвлөгөө болон хуваарь нь хэрэгжүүлэх боломжтой бөгөөд үндэслэлтэй;
- Үнэлгээг сурлагыг үнэлэх иймд форматив үнэлгээний боломжууд болон сумматив үнэлгээг агуулсан байхаар боловсруулагдсан.

Хөтөлбөрийн үнэлгээний процесс

Их, дээд сургуулийн үндсэн үйл ажиллагаа нь хэрэгжүүлж буй хөтөлбөрүүдээр дамжин явагддаг ба хөтөлбөрүүдийн чанарын асуудал тухайн сургуулийн нийт үйл ажиллагааны чанарын асуудалд чухал байр суурь эзэлнэ. Тухайн мэргэжил олгох хөтөлбөрийг судлах оюутны үйл ажиллагаа нь курс хичээлүүдийг судлах ажилд хуваагддаг бөгөөд эдгээр нь нэгдэн нийлэхээрээ зэрэг олгох нэгдмэл хөтөлбөр болж тухайн оюутны сурах үйл ажиллагааны чанарыг бүхэллэг болгож өгнө.

Хөтөлбөрийн үнэлгээний ажлын зорилго нь тухайн хөтөлбөрт багш нарын оролцоотойгоор үнэлгээ хийх замаар суралцахуйн зорилтыг оновчтой болгох юм. Хөтөлбөрийн үнэлгээ нь тухайн сургуулийн чанарын баталгаажуулалтын ажлын үндсэн бүрэлдэхүүн хэсэг бөгөөд оюутны суралцах үйл ажиллагааг тасралтгүй сайжруулахад гол анхаарлаа хандуулдаг.

Хөтөлбөрийн үнэлгээний ажлын үр дүнд тухайн хөтөлбөрийг сайжруулах үндсэн чиглэл, үйл ажиллагааны төлөвлөгөөний чиглэл гарч ирдгээрээ чухал ач холбогдолтой юм. Хөтөлбөрийн үнэлгээний ажлын ач холбогдол үүгээр хязгаарлагдахгүй:

- Хөтөлбөрийн биелэлтийг ханган цаашид улам боловсронгуй болж сайжрах бололцоо олгох
- Хөтөлбөрийн чанарын талаар нотолгоо болсон баримт бичигтэй болох
- Хөтөлбөрийн цаашдын үнэлгээний талаар мэдээлэл, зөвлөмж, стандарттай болох
- Дунд сургуулийн сургалт болон бусад байгууллага, институттэй үйл ажиллагааг хэрхэн уялдуулах талаарх санал, дүгнэлтийн талаар мэдээлэл, санаа өгөх зэрэг юм.

Хойд америк, европын их дээд сургуулиудын хөтөлбөрөө үнэлдэг шилдэг туршлагуудад үндэслэн хөтөлбөрийн үнэлгээний дараах алхмуудыг санал болгож байна.

	Үе шатууд	Ажлын нэр
1	Төлөвлөлтийн өмнөх үе шат	Хөтөлбөрийн үнэлгээний ажлын тов тогтоох
2	Төлөвлөлтийн үе шат	Хөтөлбөрийн хороо(ХХ)-ны ахлагч Хөтөлбөрийн үнэлгээний ажлын хэсэг(АХ)-ийн ахлагчийг томилно. ХХ-ны ахлагч болон ажлын хэсгийн ахлагч хамтран ажлын хэсгийн гишүүдийг томилно.
3		ХХ-ны ахлагч болон АХ-ийн ахлагч хамтран үнэлгээний ажлын зорилтыг тодорхойлно
4		АХ-ийн ахлагч тэргүүлэн ажлын хэсгийн гишүүд үнэлгээний ажлын төлөвлөгөө гаргана
5	Үнэлгээний ажлын хэрэгжилтийн үе шат	АХ-ийн ахлагч АХ-ийнхнийг үнэлгээний ажлын танилцуулга сургалтанд хамруулна
6		Хөтөлбөрийн маппинг хийх танилцуулга сургалтанд хамруулна
7		Хөтөлбөрийн маппингийн ажлыг зохион байгуулна
8		АХ үнэлгээний ажлын дүгнэлтийг боловсруулан гаргана
9		АХ ахлагч ажлын дотоод тайлан бичин ХХ-д өгнө
10		Олон нийт(ОН)-д зориулсан тайлан бичин декан, захирал, бусад төлөөллийн дунд хэлэлцүүлэг зохион байгуулна
11		ОН-д зориулсан тайлангийн эцсийн хувилбар гарна
12		Хөтөлбөрийн хороо, сургуулийн удирдлага, холбогдох тэнхим, сургалтын албанаас тайлангуудын дагуу хийх ажлын төлөвлөгөө боловсруулна
13	Ажлын төлөвлөгөөний дагуу хийсэн ажлын тайлан холбогдох алба, эрх мэдэлтнүүд хэлэлцэн, дүгнэлт гаргана.	

Ажлын хэсгийг бүрдүүлэх

Өмнө тэмдэглэсэн ёсоор хөтөлбөрийн үнэлгээний ажил нь тухайн хөтөлбөрийг хэрэгжүүлж буй багш нарын оролцоог хангасан байх зарчимд тулгуурласан. Иймд ажлын хэсэгт уг хөтөлбөрийн хичээлүүдийг зааж буй бүх багш нарыг оролцуулна. Мөн эдгээр багштай хамтран ажилладаг багш нарын төлөөллийг оролцуулах нь нээлттэй.

Ажлын хэсгийн гишүүдэд дараах материалыг бэлтгэн өгөх нь зүйтэй

- Хөтөлбөрийн үнэлгээ хийх гарын авлага, удирдамж
- Сургуулийн түвшинд тодорхойлсон суралцахуйн зорилго, зорилт (хэрэв тодорхойлогдсон бол)
- Бүрэлдэхүүн сургууль, хөтөлбөрийн суралцахуйн зорилго, зорилт (хэрэв тодорхойлогдсон бол)
- Хөтөлбөр, сургалтын төлөвлөгөө
- Сургуулийн стратеги төлөвлөгөө
- Сургалтын жилийн ажлын төлөвлөгөө
- Сургалт болон хөтөлбөртэй холбоотой журмууд
- Хэрэгжүүлж буй хөтөлбөртэй холбоотой бусад нэмэлт материалууд
- Үнэлгээний ажлын төлөвлөгөө

Хөтөлбөрийн матриц буюу маппинг

Хөтөлбөрийн маппинг нь хичээл болон суралцахуйн зорилтыг хооронд нь уялдаатай болгоход чиглэсэн арга юм. Маппингийг ихэвчлэн хичээлүүдийг эхний багана, суралцахуйн зорилтуудыг эхний мөр болгосон матриц авч мөр, баганын огтлолцол дээр тухайн хичээлээр харгалзах суралцахуйн зорилтыг ямар түвшинд хэрэгжүүлж буйг зааж өгдөг.

Хөтөлбөрийн матриц нь дараах хэлбэртэй байдаг.

Хичээл	Суралцахуйн зорилтууд			
	Суралцахуйн зорилт 1	Суралцахуйн зорилт 2	Суралцахуйн зорилт 3	Суралцахуйн зорилт 4
Хичээлийн нэр, индекс 1	Ү	Ү		Ү
Хичээлийн нэр, индекс 2	Б	Б	Б	
Хичээлийн нэр, индекс 3	Б	Э, Ү	Б	
Хичээлийн нэр, индекс 4	Э, Ү		Э, Ү	Б
...				

Түлхүүр үг: "Ү"=Үндсэн ойлголт төлөвшүүлэх; "Б"=ойлголтыг бататган, дадлагажих боломж олгоно; "Э"=Илүү өндөр түвшинд эзэмшинэ; "Ү"=Үнэлгээнд зориулж нотлох баримт цуглуулна.

Хөтөлбөрийн маппинг нь:

- Юуг хэзээ зааж байгааг баримтжуулж нэгтгэн харуулдаг
- Хөтөлбөр дэхь хоосон зай, заагийг илрүүлж харуулна
- Үнэлгээний төлөвлөгөө гаргахад туслана

Энэ аргын давуу талууд:

- Багш, профессоруудын хоорондох харилцаа, холбоог дээшлүүлнэ
- Хөтөлбөрийн нийцтэй байдлыг дээшлүүлнэ
- Суралцагч хөтөлбөрийн түвшний зорилгыг биелүүлэх магадлалыг дээшлүүлнэ
- Хөтөлбөрийг эргэн харах боломж олгоно

Үнэлгээний ажлын тайлан

Үнэлгээний ажлын үр дүнг ХХ, Төв болон салбар сургуулийн удирдлага, тэнхмийн эрхлэгч, болон башг нарт зориулсан дотоод тайлан, олон нийт, хариуцсан яам, оролцогч талуудад зориулсан олон нийтэд зориулсан тайлан гэсэн хоёр хэсэгт хуваан боловсруулах нь зүйтэй.

Дотоод тайланд

- 1. Товч танилцуулга:** Хөтөлбөрийн талаар товч танилцуулга (хөтөлбөр хэрэгжсэн түүх, одоогийн байдал, магадлан итгэмжлэлтэй холбоотой мэдээлэл гэх мэтийг багтаасан 0.5-1 хуудас)
- 2. Хөтөлбөрийн талаарх дэлгэрэнгүй танилцуулга:**
 - Хөтөлбөрийн түвшин дэхь суралцахуйн зорилт: тухайн хөтөлбөрөөр төгсөгчийн ээмших мэдлэг, үр чадвар
 - Хөтөлбөрийн бүтэц: заавал болон сонгох үзэх хичээлүүд, хэвтээ болон босоо холбоо, хичээлийн бүтэц(лекц, сем, лаб, төсөлт ажил г.м.), дадлага, суралцах болон судалгааг хослуулдаг эсэх, интернационалчлалтай холбоотой асуудлууд, сурах үйл ажиллагаатай холбоотой тусгайлсан нөхцөл байдал, бусад хөтөлбөртэй хэрхэн холбогдох г.м асуудлуудыг хамарна.
- 3. Чиглүүлэх асуултууд:** тухайн хөтөлбөрийн хувьд үнэлгээний ажлын чиглүүлэг болохуйц ноцтой асуудал байгаа эсэх
- 4. Хөтөлбөрийн матриц/маппинг:** Бүх хичээлийн хувьд хөтөлбөрийн матриц буюу маппингийг хийх ёстой ба тусгайлсан програм хангамж ашиглаж болно.
- 5. Хөтөлбөрийн матриц/маппингийн үр дүнд хийсэн дүн шинжилгээ:** агуулгын хувьд хичээл, хугацааны хувьд орхигдсон, хоцорсон зүйл байгаа эсэх, суралцахуйн

зорилго, зорилт, заах арга зүй, үнэлгээний зорилго, стратеги талаас хийх шаардлагатай зохицуулалт, тохируулга байгаа эсэх, сургалтын төлөвлөгөөнд зохицуулалт, тохируулга хийх шаардлагатай эсэх

6. **Бусад эх сурвалжаас авсан нотлох баримт, өгөгдлүүд:** суралцагчдын тоо болох хөтөлбөр хичээлтэй холбоотой статистик өгөгдөл, мэдээнүүд, оюутны санал асуулгын дүн гэх мэт.
7. **Дүгнэлт:** Хөтөлбөрийн матриц, маппинг болон бусад эх сурвалжаас авсан мэдээлэл, дүн шинжилгээнүүдээс үүдсэн дүгнэлт. Үүнд үндэслэн үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулна
8. **Үйл ажиллагааны төлөвлөгөө:** Хөтөлбөрийн ээлжит үнэлгээний хугацаанд хийх ажлын төлөвлөгөөг 5,6,7-д хийсэн зүйлүүд дээр үндэслэн гаргана. Үйл ажиллагааны төлөвлөгөөнд мөн дараагийн үнэлгээ хүртлэх хугацаанд хэрэгжүүлэх дунд хугацааны ажлын төлөвлөгөөг дагалдуулж болно.

Дүгнэлт

Дотоод чанарын баталгаажилтын үйл явцаар дамжин үйл ажиллагаагаа сайжруулахыг зорьж буй Дээд боловсролын байгууллага нь дараах бичиг баримтуудыг бүрдүүлэх шаардлагатай:

- Төгсөгчдийн цогц чадамжыг томъёолсон томъёолол.
- Каррикулумын матриц /маппинг.
- Сургуулийн суралцах хөтөлбөрийн бичиг баримтууд.
- Хөтөлбөрийн үнэлгээнд ашиглагдах, дэмжих баримт бичгүүд (жишээ нь, хөтөлбөрийн үнэлгээний хурал, семинаруудын тэмдэглэл).
- Сургалтын төлөвлөгөө, силлабус (хичээлийн тодорхойлолт, хичээлийн төлөвлөгөө).
- Үнэлгээ, хөтөлбөрийн үнэлгээний стандарт үйл ажиллагаа, бүтэц.
- Эцсийн үнэлгээний удирдамж.
- Оюутны суралцах дундаж хугацаатай холбоотой өгөгдлийг гаргаж авахад зориулсан дэмжих материалууд.
- Үнэлгээний хэрэгслэлийн жишээнүүд (шалгалтын даалгавр, үнэлгээ, гэрийн даалгавар, г.м).

ДББ-ууд бусад сургуулиудын ижил төстэй агуулга, түвшин бүхий хичээлүүдийг хүлээн зөвшөөрөх, ийм хөдөлгөөнийг дэмжих нь тухайн байгууллагууд төдийгүй нийт ДБ-ын системд чанарын баталгаажилтыг бий болгох, бататгахад чухал нөлөөтэй юм.

Их дээд сургуулиудын консорциумын хэмжээнд гадаад төдийгүй дотоодын их, дээд сургуулиудад чанарын баталгаажилтыг хэрхэн хангаж буй шилдэг туршлагыг байнга түгээн дэлгэрүүлэх нь зүйтэй.

REFERENCES

EHEA (2015) Standards and Guidelines for Quality Assurance in the European Higher Education Area (ESG); Brussels, Belgium.

UNESCO (2005) Guidelines for Quality Provision in Cross-border Higher Education; Paris, France